



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ТУШААЛ

2019 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 04


Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Барилга байгууламжийн норм, нормативын сангийн журам”-ыг нэгдүгээр, Сангийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, Сангийн хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 46 дугаар тушаал, 2018 оны 95 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.


Х.БАДЕЛХАН

Барилга, хот байгуулалтын сайдын
2019. оны 01 дугаар сарын 01-ны өдрийн
01 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН НОРМ, НОРМАТИВЫН САНГИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Барилга байгууламжийн норм, нормативын сан /цаашид “Сан” гэх/-гийн журмын зорилго нь Барилгын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5, 5.7, 5.8 дахь хэсгийг хэрэгжүүлж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн судалгаа хийх, боловсронгуй болгох, өөрийн орны нөхцөлд тохирсон үндэсний норм, нормативын баримт бичгийг боловсруулах, батлуулах болон хэвлүүлэх, сурталчлахад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, зориулалтын дагуу зарцуулах үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Сангийн удирдах зөвлөлийн баталсан төлөвлөгөөний дагуу барилгын норм, нормативын баримт бичгийн төслийг боловсруулах ажлыг зохион байгуулах чиг үүргийг Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 51 дүгээр тогтоолыг үндэслэн “Барилгын хөгжлийн төв” ТӨААҮГ /цаашид “Барилгын хөгжлийн төв” гэх/, батлах ажлыг Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхлэн гүйцэтгэнэ.

1.3. Сангийн хөрөнгөөр барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг боловсруулахад салбарын эрдэм шинжилгээ, судалгаа, шинжлэх ухааны байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, барилгын ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээд, иргэдийг оролцуулах зарчмыг баримтална.

1.4. Сан нь эх үүсвэрээ бүрдүүлэх, түүнийг зориулалтын дагуу зарцуулах, ажлын үр дүнгээ тайлагнах үйл ажиллагааг Барилгын хөгжлийн төвийн дэргэд хууль тогтоомжийн хүрээнд явуулж, мэдээллээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд түгээнэ. Сан нь Барилгын хөгжлийн төвийн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудсыг хэрэглэнэ.

1.5. Сангийн хөрөнгийн орлого, зарлагын баримтад Барилгын хөгжлийн төвийн захирал, ерөнхий нягтлан бодогч нар 1, 2 дугаар гарын үсгийг тус тус зурна.

1.6. Сангийн хөрөнгийн зарцуулалттай холбогдсон анхан шатны баримт бичиг, нягтлан бодох бүртгэл хөтлөх үйл ажиллагаа нь Барилгын хөгжлийн төвийн нягтлан бодох бүртгэл хөтлөх үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг байна.

Хоёр. Сангийн удирдлага, зохион байгуулалт

2.1. Сангийн удирдах зөвлөл /цаашид “Удирдах зөвлөл” гэх/ нь 9-13 гишүүнтэй байна. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

2.2. Удирдах зөвлөлийн дарга нь барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга байна.

2.3. Удирдах зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.3.1. барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг боловсруулах жишиг үнэлгээг тогтоох;

2.3.2. Сангийн үйл ажиллагааны жилийн болон дунд хугацааны төлөвлөгөө, төсвийг хянан хэлэлцэж батлах;

2.3.3. барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн боловсруулалтын явцыг хэлэлцэж, эрчимжүүлэх, шаардлагатай арга хэмжээ авах;

2.3.4. Сангийн үйл ажиллагаа, хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтын жилийн тайланг хэлэлцэж дүгнэх;

2.3.5. барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг боловсруулахад онцгой үүрэг гүйцэтгэсэн иргэн, төслийн баг, аж ахуйн нэгжийг урамшуулах асуудлыг шийдвэрлэх.

2.4. Удирдах зөвлөл нь тайлант жилдээ багтаан Сангийн үйл ажиллагааны тухайн жилийн тайланг хэлэлцэн дүгнэж, дараа оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг баталсан байна.

2.5. Удирдах зөвлөлийн хуралдаан нь бүх гишүүдийн гуравны хоёроос доошгүй гишүүний ирцтэй хуралдаж, олонхийн саналаар шийдвэр гаргана.

2.6. Удирдах зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэсэн асуудлаар тэмдэглэл хөтөлж, түүнийг Удирдах зөвлөлийн дарга баталгаажуулна.

2.7. Удирдах зөвлөлийн дарга дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.7.1. Сангийн удирдах болон хяналтын зөвлөлийн гишүүдийг томилуулах, өөрчлөх талаар санал боловсруулж, барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж, шийдвэрлүүлэх;

2.7.2. барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, Сангийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах бүх талын арга хэмжээ авч ажиллахын зэрэгцээ норм, нормативын баримт бичгийн ач холбогдлыг харгалзан тэдгээрийг боловсруулах дарааллыг тогтоож, гүйцэтгэж байгаа ажлуудын явцыг хянаж, эрчимжүүлэх арга хэмжээ авах;

2.7.3. Сангийн үйл ажиллагааны болон норм, нормативын баримт бичиг боловсруулах жилийн болон дунд хугацааны төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

2.7.4. Сангийн зорилго, үйл ажиллагаатай холбогдох асуудлаар иргэн, хуулийн этгээдтэй гэрээ, хэлцэл байгуулах, дүгнэх;

2.7.5. Сангийн хөрөнгийн зориулалт, бүрдүүлэлт, зарцуулалтын талаар илэрсэн зөрчил, дутагдлыг цаг тухайд нь арилгуулах.

2.8. Барилгын хөгжлийн төвийн норм, норматив боловсруулах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий нэгж нь Сангийн ажлын алба байх бөгөөд дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэнэ. Үүнд:

2.8.1. Сангийн үйл ажиллагааны дунд хугацааны болон тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулах;

2.8.2. Сангийн үйл ажиллагааны болон хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтын тайланг улирал бүр гаргаж, дараа сарын 5-ны дотор Сангийн хяналтын зөвлөлд хүргүүлэх;

2.8.3. Барилгын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8 болон энэ журамд заасны дагуу удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн Сангийн хөрөнгийг зарцуулах;

2.8.4. Сангийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг гүйцэтгэхээр сонгон шалгаруулсан этгээдтэй гэрээ байгуулах, дүгнэх;

2.8.5. барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг боловсруулах ажлыг зохион байгуулах, мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

2.8.6. барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг боловсронгуй болгох, олон улсын түвшинд хүргэх чиглэлээр судалгаа, шинжилгээ хийж, үндсэн чиглэл, хөтөлбөр боловсруулах, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр төсөл хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, гадаад орны туршлага судлах, тэднээс шаардлагатай норм, нормативын баримт бичиг, мэдээлэл худалдан авах;

2.8.7. Санд хөрөнгө төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах;

2.8.8. барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг болон түүнтэй холбогдсон эх материалыаар фонд, мэдээллийн сан байгуулах, түүнийг тогтмол баяжуулах;

2.8.9. салбарын хууль тогтоомж, барилгын норм, нормативын баримт бичгийн жагсаалтыг эмхэтгэл болгон хэвлүүлэх, нийтэд түгээх, сурталчлах;

2.8.10. батлагдсан төлөвлөгөөний хүрээнд барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг боловсруулахад шаардлагатай ном хэвлэл, аргачлал, шаардлагатай тоног төхөөрөмж, материал худалдаж авах, норм, нормативын электрон сан бий болгох, эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр туршлага судлах, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах;

2.8.11. барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг батлахтай холбогдуулан боловсруулсан суурь судалгааны баримт бичиг, зохих байгууллагын шүүмж, редакц, санал, дүгнэлтийг хадгалах;

2.8.12. Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх асуудлын төслийг бэлтгэж хурлаар хэлэлцүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

2.9. Барилгын хөгжлийн төв нь Санд төвлөрүүлэх хөрөнгийг төвлөрүүлээгүй буюу дутуу төвлөрүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагаар уг хөрөнгийг нөхөн төлүүлэх түүнчлэн хөрөнгө төвлөрүүлэх үүргээ бүрэн биелүүлээгүй аж ахуйн нэгж, байгууллагад Барилгын тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.8-д заасан хариуцлагыг тооцуулахаар холбогдох байгууллагад санал тавьж, шийдвэрлүүлнэ.

Гурав. Санд хөрөнгө төвлөрүүлэх

3.1. Сан нь Барилгын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

3.2. Аж ахуйн нэгж, байгууллага нь санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг оны эхний өссөн байдлаар дараах байдлаар тооцож улирал бүрийн дараа сарын 5-ны дотор Сангийн дансанд төвлөрүүлнэ. Үүнд:

3.2.1. тухайн жилд гүйцэтгэсэн барилга угсралт¹ /засвар/-ын төсөвт өртгийн нэмэгдсэн өртгийн албан татвар /НӨАТ/ тооцоогүй үнийн дүнгээс 0.18 хувиар,

3.2.2. өргөх байгууламжийн угсралтын ажлын үнийн дүнгээс 0.18 хувиар,

3.2.3. зураг төсөл, хайгуул, судалгааны ажлын үнийн дүнгийн 0.18 хувиар тус тус тооцно.

3.3. Санд төвлөрүүлэх хөрөнгийн ногдуулалт, төлөлтийн тайланг батлагдсан маягтын дагуу гаргаж тухайн оны 12 дугаар сарын 15-ны дотор гаргаж тайлагнана.

Дөрөв. Сангийн хөрөнгийн зориулалт

4.1. Сангийн хөрөнгийг дараах арга хэмжээнүүдэд зориулан зарцуулна. Үүнд:

4.1.1. Сангийн үйл ажиллагааны зардал;

4.1.2. барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг судлах, боловсруулах, суртачлах, хэвлэх, түүнтэй холбогдсон зардал, /гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, зар сурталчилгаа хийх/;

4.1.3. салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, холбогдох хуулийн төсөл, дүрэм, журмуудыг боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах;

4.1.4. салбарын хуулийн болон норм, нормативын баримт бичгийн талаар олон улсын туршлага судлах, гадаад, дотоод сургалтад хамрагдах;

4.1.5. хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм, нормативын баримт бичиг, барилгын салбарын холбогдолтой хууль, эрх зүйн баримт бичгийн эмхэтгэлийг шинэчлэн эмхэтгэж, хэвлүүлэх;

4.1.6. барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг боловсруулахад шаардагдах ном хэвлэл, аргачлал, тооцоо судалгааны болон шаардлагатай бусад материал, тоног төхөөрөмж худалдаж авах;

4.1.7. олон улсын мэргэжлийн байгууллагуудтай холбоо тогтоох, хамтран ажиллах;

4.1.8. норм, нормативын баримт бичиг боловсруулахтай холбогдсон хурал, зөвлөгөөн, сургалт семинар зохион байгуулах;

¹ Тайлбар: Барилга угсралтын төсөвт өртөгт барилгын материалын үнэ орсон болно.

4.1.9. норм, нормативын баримт бичиг боловсруулах чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх.

4.2. Сангийн хөрөнгийг хууль болон энэ журамд зааснаас бусад зориулалтаар ашиглах, дараах чиглэлийн арга хэмжээнд зарцуулахыг хориглоно. Үүнд:

4.2.1. байгууллага, хувь хүнийг ивээн тэтгэх, хандив өргөх;

4.2.2. байгууллага, аж ахуйн нэгжийн алдагдал нөхөх, баталгаа гаргах.

Тав. Сангийн үйл ажиллагааг тайлагнах, хяналт тавих

5.1. Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулж буй байгууллага нь Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтын тайланг хагас, бүтэн жилээр гаргаж Сангийн удирдах зөвлөл, барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад танилцуулна.

5.2. Тухайн жилд боловсруулах норм, нормативын баримт бичгийн жагсаалтыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

5.3. Сангийн хяналтын зөвлөл нь 5 гишүүнтэй байх бөгөөд бүрэлдэхүүнийг барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

5.4. Сангийн хяналтын зөвлөл нь Сангийн үйл ажиллагаа, хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтанд жилд нэгээс доошгүй удаа хяналт, шинжилгээ хийж тайланг Сангийн удирдах зөвлөл болон барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна.

-----оо-----

Барилга, хот байгуулалтын сайдын
2019. оны 05 дугаар сарын 05-ны өдрийн
сүрье дугаар тушаалын 2 дугаар хавсралт

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН НОРМ, НОРМАТИВЫН САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Удирдах зөвлөлийн дарга:

Барилга, хот байгуулалтын яамны Төрийн
нарийн бичгийн дарга

Гишүүд:

Барилга, хот байгуулалтын яамны Бодлого,
төлөвлөлтийн газрын дарга

Барилга, хот байгуулалтын яамны Барилга,
барилгын материалын үйлдвэрлэлийн
бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын
дарга

Барилга, хот байгуулалтын яамны Хот
байгуулалт, газрын харилцааны бодлогын
хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Барилга, хот байгуулалтын яамны Инженерийн
дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах
газрын дарга

Барилга, хот байгуулалтын яамны Төрийн
захиргааны удирдлагын газрын Санхүүгийн
хэлтсийн дарга

“Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын захирал
Ц.Амарсанаа

“Монголын барилгын зураг төсөл зохиогчдын
холбоо” ТББ-ын Ерөнхийлөгч Н.Дорж

“Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ-
ын Удирдах зөвлөлийн гишүүн Б.Нэмэхбаатар


“Монголын барилгын инженерүүдийн холбоо”
ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн
Л.Шагдаррагчаа

Нарийн бичгийн дарга:

Барилга, хот байгуулалтын яамны Бодлого,
төлөвлөлтийн газрын Норм, нормативын
асуудал хариуцсан мэргэжилтэн

Барилга, хот байгуулалтын сайдын
2019. оны 41 дугаар сарын 03-ны өдрийн
04 дугаар тушаалын 3 дугаар хавсралт

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН НОРМ, НОРМАТИВЫН САНГИЙН
ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**



Дарга:

Барилга, хот байгуулалтын яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга

Гишүүд:

Барилга, хот байгуулалтын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга

Барилгын техникийн хяналтын улсын байцаагч /тохиролцсоноор/

Салбарын төрийн бус байгууллагын төлөөлөл

Нарийн бичгийн дарга:

Барилга, хот байгуулалтын яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дотоод аудит хариуцсан мэргэжилтэн